

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ЭЭЛЖИТ
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС
ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 02 дугаар сарын 08-ны өдөр

Улаанбаатар хот

ДД	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
	<p>Үүрэг даалгавар НЭГ: Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах арга хэмжээний тухай” А/32 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлийн бүх үе шатанд тавих хяналтыг эрчимжүүлж ажиллах</p>			
1	<p>Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд шинээр хэрэгжүүлэх 23 төсөл арга хэмжээ батлагдсанаас бэлтгэл ажлын шатанд 5, тендерийн шалгаруулалтын шатанд 18 төсөл арга хэмжээ хэрэгжиж байна. Он дамжин хэрэгжих 48 төсөл арга хэмжээ батлагдсанаас бэлтгэл ажлын шатанд 2, тендер шалгаруулалтын шатанд 6, гэрээ байгуулан ажил үргэлжилж буй 17, бүрэн дуусган хүлээлгэн өгсөн 23 төсөл арга хэмжээ байна.</p> <p>Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх 24, он дамжин хэрэгжих 11 төсөл арга хэмжээнээс тендерийн шатанд 1, гэрээ байгуулан ажил үргэлжилж буй 1, бүрэн дуусгаж хүлээлгэн өгсөн 9 төсөл арга хэмжээ байна.</p> <p>Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 28 дугаар тогтоолоор батлагдсан дүүргийн төсвийн хөрөнгөөр 2023 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах ажлыг хуулийн хугацаанд зохион байгуулж явцын гүйцэтгэл, санхүүжилтэд хяналт тавин ажиллаж байна.</p> <p>Дүүргийн Газар зохион байгуулалтын албанаас улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээний бэлтгэл ажлыг шуурхай зохион байгуулж, Нийслэлийн Газрын албаны Газар чөлөөлөх хэлтэстэй хамтран нөхөн олговортойгоор газар чөлөөлөх ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна.</p> <p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2023 оны “Эрх шилжүүлэх тухай” А/52 дугаар захирамжийг 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 3/188 дугаарын албан бичгээр дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд хүргүүлэн захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд;</p> <ul style="list-style-type: none"> ➢ Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжих “Ерөнхий боловсролын сургуульд Олон улсын хөтөлбөр” хэрэгжүүлэх нийт 17 ажлын техникийн даалгаврыг 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 3/134 дугаартай албан бичгээр; ➢ Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжих Ерөнхий боловсролын 61 дүгээр сургуулийн Урлаг заалыг засварлах ажлын зураг, төсөв, магадлалын дүгнэлт; ➢ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжүүлэх “Ногоон бүс” камержуулалтын ажлын 1, 2, 3, 4 дүгээр багц; ➢ Дүүргийн Нийтлэг үйлчилгээний газрын /ОНӨҮГ/ хэрэгцээнд шаардлагатай машин 			70

	<p>механизм худалдан авах техникийн тодорхойлолтыг хянуулахаар дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд тус тус хүргүүлсэн.</p> <p>Улс, нийслэл, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнд 14 хоногт 1 удаа явцын хяналт хийн ажиллаж байна.</p> <p>Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн “Эрх шилжүүлэх тухай” А/52 дугаар захирамжаар Чингэлтэй дүүрэгт 3 төсөл арга хэмжээний эрх шилжсэний дагуу дүүргийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/36, А/37, А/38 тоот захирамжаар үнэлгээний хороо байгуулан, захиалагчаас зураг төсөв, ажлын даалгаврыг 3 хоногт багтаан www.tender.gov.mn, www.chingeltei.gov.mn цахим хаягт байршуулан ажилласан.</p>			
<p>Үүрэг даалгавар ХОЁР: Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Төсвийн хуваарь батлах тухай” А/47 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангаж, төсвийн орлого бүрдүүлэлтийг эрчимжүүлэх</p>				
2	<p>Дүүргийн хэмжээнд 2023 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн байдлаар:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Улсын төсөвт: 3,722,444,0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 4,219,525.0 мянган төгрөг төвлөрүүлж 119.1%, ➢ Нийслэлийн төсөвт 9,645,037,7 мянган төгрөг төвлөрүүлэхээс 9,645,037,8 мянган төгрөг төвлөрүүлж 100%-ийн биелэлттэй; ➢ Дүүргийн төсөвт 13,791.9 сая төгрөг төвлөрөхөөс 17,361.1 сая төгрөг төвлөрч 126%-ийн биелэлттэй байна. <p>Цаашид төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг жигд ханган, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажлуудыг эрчимжүүлж ажиллахаар төлөвлөж байна.</p>			100
<p>Үүрэг даалгавар ГУРАВ: “Хот хөгжлийн индекс” хэрэгжүүлэхтэй холбогдуулан нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд Нийслэлийн Бодлогын судалгаа шинжилгээний төвтэй хамтран ажиллаж, шаардлагатай судалгаа, мэдээ мэдээлэл шуурхай солилцож, ажлыг уялдуулж ажиллах</p>				
3	<p>Хотын хүний хөгжлийн индексийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах хүрээнд Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хот байгуулалт, дэд бүтэц, үйлдвэр үйлчилгээ, гэр хорооллын хөгжлийн хороотой хамтран 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдөр Нийслэлийн Бодлогын судалгаа, шинжилгээний төвийн үйл ажиллагаатай танилцсан. Мэдээлэл солилцох, үйл ажиллагаатай танилцах арга хэмжээнд дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс албадын дарга, мэргэжилтэн, нийт 24 албан хаагч хамрагдаж, судалгаа, мэдээ мэдээлэл солилцох, ажлын уялдаа холбоог сайжруулах уулзалт сургалтад хамрагдсан.</p>			70
<p>Үүрэг даалгавар ДӨРӨВ: Удирдлагын академитай хамтран “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх хүрээнд “Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь” богино хугацааны сургалтад Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдах албан тушаалтнууд биечлэн оролцох. Сургалт: 2023 оны 02 дугаар сарын 03, 04-ний өдрүүдэд Удирдлагын академийн байранд зохион байгуулна/</p>				
4	<p>Монгол улсын Засгийн газрын “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын эхний үе шат “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх хүрээнд “Хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь” богино хугацааны сургалтын тов, чиглэл ирээгүй байна.</p>			
<p>Үүрэг даалгавар ТАВ: Нийслэлийн хэмжээнд Сар шинийн баярын үзэсгэлэн худалдаа болон Ерөнхий боловсролын сургуулийн хичээл эхэлж байгаатай холбогдуулан иргэд, хүүхэд, багачуудын амгалан тайван байдлыг хангах, хулгайн болон бусад төрлийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хэв журмыг сахиулах ажлуудаа эрчимжүүлэх.</p>				

5	<p>Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан “Чингэлтэйд үйлдвэрлэв-2024” арга хэмжээ, дүүргийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Үйлдвэрлэлийг дэмжих жил”-ийн хүрээнд Уламжлалт сар шинийн баярыг тохиолдуулан дотоодын эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэр эрхлэгчдээ дэмжих “Амар байна уу-2023” сар шинийн өргөтгөсөн үзэсгэлэн худалдаанд дүүргийн 70 жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг оролцуулж, 97,0 /ерэн долоон сая/ төгрөгийн борлуулалтыг хийж ажилласан. Чингэлтэй дүүргийн “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв”-өөс санаачлан “Амар байна уу-2023” үзэсгэлэн, худалдааны хүрээнд жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор “Шинэ зуун айл” худалдааны төвд 2023 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр дүүргийн төрийн албан хаагчид болон иргэд, үйлдвэр эрхлэгчдийг оролцуулан нээлт хийж, “Шагай наадгай”, “Дэмбээ”, “Шагайн харваа”, дууны тэмцээнүүдийг зохион байгуулж, урлагийн тоглолтоор олон нийтэд үйлчилж, үйл ажиллагааг сурталчлан ажилласан.</p> <p>Дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиуд сурагчдын амгалан тайван байдлыг хангах, хулгайн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хэв журмыг сахиулах ажлуудыг эрчимжүүлэн “School police” эцэг эхийн эргүүлийг тогтмол ажиллуулж, сургууль тус бүр 1-5 дугаар ангийн сурагчдыг “Гараас гарт” зарчмыг баримтлуулан, замын хөдөлгөөнд хэрхэн оролцох талаар “Өсвөрийн сэргийлэгч” клубийн сурагчдаар яриа таниулга хийлгэж байна. Боловсролын хэлтсээс эцэг эхчүүд, сурагчдад зориулан аливаа гэмт хэргээс урьдчилан сэргийлэх постер, мэдээллийг цахим орчин болон мэдээллийн самбараар, анги удирдсан багш нараар дамжуулан анхааруулга, зөвлөмжүүдийг хүргэсэн.</p> <p>“Ногоон гэрэл цагаан шугам” уралдааныг дүүргийн ерөнхий боловсролын 20 сургуулиудын дунд амжилттай зохион байгуулж, 1-5 дугаар ангийн сурагчдад “Шар дарцаг” аяныг хэрэгжүүлэн ажиллаж байна.</p> <p>Хүүхдийн автобусаар зорчдог сурагчдыг аюулгүй тээвэрлэх 2023140005 дугаартай заавар, зөвлөмжийг автобусны жолооч болон хүүхэд зохицуулагч нарт сургуулийн Нийгмийн ажилтнууд өдөр тутамд өгч ажилласан. Дүүрэг дэх Цагдаагийн газраас уламжлалт Сар шинийн баярыг тохиолдуулан гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр эргүүл хяналт шалгалтыг 10 чиглэлд 20 алба хаагч өдөр тутам зохион байгуулан ажиллаж байна.</p> <p>“Сар шинэ” нэгдсэн арга хэмжээний хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> ➢ Халаасны хулгайн гэмт хэрэг ихээр үйлдэгддэг цаг болон эмзэг цэгүүдэд эргүүл хяналт шалгалтыг эрчимжүүлэн 5 чиглэлд 10 алба хаагч үүрэг гүйцэтгэж, авто эргүүлийн чанга яригчаар иргэдэд сэрэмжлүүлэг мэдээллийг хүргэн ажиллаж байна. ➢ Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Нарлаг дэнж”, “Хүчит шонхор”, “Нарантуул-2”, “Дөрвөн шонхор” худалдааны төвүүдийн ойр орчим амралтын өдрүүдэд дрон нисгэн, хяналт тавьж ажилласан. ➢ Дүүргийн 61, 138, 39 дүгээр сургуулийн 145 сурагч болон 220 дугаар цэцэрлэгийн 25 ажилтан багш нарт дүүргийн Онцгой байдлын хэлтэс, “Таван толгой түлш” ХХК-тай хамтран галын аюулгүй, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулан мэдээ, мэдээлэл өгсөн ба дүүрэг дэх Цагдаагийн газрын цахим хуудсанд Сар шинэ нэгдсэн арга хэмжээний хүрээнд 3 төрлийн сэрэмжлүүлэг бэлтгэн иргэд, олон нийтэд түгээж ажиллалаа. 			90
---	--	--	--	----

Үүрэг даалгавар ЗУРГАА: Золбин нохой, муур устгах ажлыг эрчимжүүлж ажиллах			
	Золбин нохой, муур устгах ажлын хүрээнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны гэрээтэй "Их булаг" ХХК, "Өлтэй" ХХК дүүргийн 7-24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 2023 оны 01 дүгээр сарын 26-ны өдрөөс 02 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл хугацаанд нийт 324 нохой, 2 муурыг устгасан. Мөн хороодын Засаг дарга нар нутаг дэвсгэрийн тэжээвэр нохойтой айл өрхүүдэд нохойгоо өдрийн цагаар (06:00-23:00) уяж хэвших, хашаа хаалга орчимдоо нохойтой тухай анхааруулга байрлуулах, шаардлагатай вакцин, тарилгад нь тогтмол хамруулах зөвлөмжийг өрх бүрд хэсгийн ахлагч нар хүргэн ажиллаж байна.		70

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Л.БАЯРМАА

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

Н. НАРАНЗУЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Н.ЭНХГЭРЭЛ

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Т.ТҮВШИНЖАРГАЛ